



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 21 оны 09 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шадар сайдын 2018 оны 45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өнцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т даалгасугай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН

0021100416

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны
12 дугаар сарын 12 ны өдрийн 12 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.20.1, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ын 5.2-т заасныг хэрэгжүүлэх үүрэг бүхий Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөл (цаашид “Мэргэжлийн зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Мэргэжлийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай хууль, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Хоёр. Мэргэжлийн зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Мэргэжлийн зөвлөл нь дарга, орлогч дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэх бөгөөд Мэргэжлийн зөвлөлийн дарга нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна.

2.2. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, тухайн чиглэлийн асуудал хариуцсан яам, агентлаг, боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл, бие даасан шинжээч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.3. Мэргэжлийн зөвлөлийн гишүүд нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журамд заасан тухайлсан салбарт 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байна.

2.4. Мэргэжлийн зөвлөл нь галын мэргэжлийн салбар зөвлөл /цаашид “Салбар зөвлөл” гэх/-ийг удирдлагаар хангана.

2.5. Мэргэжлийн зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, шударга ёсыг баримтлах, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.

Гурав. Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан

3.1. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр нь хуралдааны тэмдэглэл байна. Мэргэжлийн зөвлөл нь жилд 1 удаа хуралдаж, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

3.2. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн 50 хувиас дээш оролцсон тохиолдолд хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.

3.3. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр нь хуралдаанд оролцсон гишүүдийн 50 хувиас дээш нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болох бөгөөд Мэргэжлийн зөвлөлийн дарга хурлын тэмдэглэлд гарын үсэг зурснаар шийдвэр баталгаажна.

3.4. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг зөвлөлийн даргаар батлуулж, хуралдааны товыг зөвлөл хуралдахаас 5-аас доошгүй хоногийн өмнө хуулийн этгээдийн талаарх баримт бичиг, материалын хамт гишүүдэд хүргүүлнэ.

3.5. Мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, хуралдаанаас хойш ажлын 5 өдөрт багтаан албажуулна.

3.6. Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шаардлагатай тохиолдолд холбогдох салбарын мэргэжилтнийг Мэргэжлийн зөвлөлийн даргын зөвшөөрснөөр оролцуулж болох бөгөөд саналын эрх эдлэхгүй.

Дөрөв. Мэргэжлийн зөвлөлийн бүрэн эрх

4.1. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, салбар зөвлөлөөс гаргасан зөвлөмж, дүгнэлтийг хэлэлцэх,

4.2. Хуулийн этгээдээс гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авах тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлах, өргөдлийг хүлээн авах, холбогдох журам, шалгуур үзүүлэлтийн дагуу шинжилгээ хийнэ.

4.3. Хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана.

Тав. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний тайланд хяналт, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа

5.1. Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ын 5.4, 5.5-д заасан ерөнхий шинжээч, шинжээч, шинжээчийн баг нь гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс ирүүлсэн "Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ (цаашид "нарийвчилсан үнэлгээ" гэх)-ний тайланд хяналт тавьж, дүгнэлт гаргана.

5.2. Ерөнхий шинжээч нь шинжээч, шинжээчийн багийг удирдлага, зөвлөмжөөр хангана.

5.3. Нарийвчилсан үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийхдээ холбогдох заавар, стандарт, Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам"-ын 8.2-т заасны дагуу батлагдсан шалгуур үзүүлэлтийг баримтална.

5.4. Дүн шинжилгээ хийхдээ нарийвчилсан үнэлгээний тайлантай холбоотой нэмэлт тодруулга, тайлбар, мэдээллийг үнэлгээ гүйцэтгэсэн хуулийн этгээд, үнэлгээ хийлгэсэн захиалагч талаас тухай бүр гаргуулж болно.

5.5. Нарийвчилсан үнэлгээний тайланг зааврын дагуу боловсруулаагүй гэж үзвэл хуулийн этгээдэд буцаан, сайжруулалт хийх зөвлөмж хүргүүлнэ.

5.6. Нарийвчилсан үнэлгээний тайланг хянуулах тухай албан бичгийн хамт хүлээн авсан өдрөөс анхан шатны болон дүгнэлт гаргах үе шат тус бүрт ажлын 15 хоног, сайжруулалт хийлгэхээр буцаасан тайланг дахин хүлээн авсан өдрөөс ажлын 10 хоногт багтаан дүн шинжилгээ хийнэ. Шаардлага хангасан тайланд дүгнэлт гаргана.

5.7. Буцаасан нарийвчилсан үнэлгээний тайланд ажлын 15 хоногт багтаан сайжруулалт хийх бөгөөд хугацааг нэг удаа сунгаж болно. Хоцроосон тайланг дахин хүлээн авахгүй.

5.8. Тайлан сайжруулалтыг 3 удаа хангалтгүй ирүүлсэн тохиолдолд тайланг үргэлжлүүлэн хянах боломжгүй тухай хариуг нарийвчилсан үнэлгээ гүйцэтгэсэн хуулийн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ. Нарийвчилсан үнэлгээний тайланг хянах боломжгүй тухай албан бичиг 3 удаа хүргүүлсэн тохиолдолд тухайн хуулийн этгээдийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах үндэслэл болно.

5.9. Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд ерөнхий шинжээч, шинжээч

нарийвчилсан үнэлгээний тайлан хүлээн авч дүгнэлт гаргасан тухай мэдээллийг танилцуулна.

5.10. Энэ журмын 5.7-д заасан нөхцөлийг бүрдүүлсэн болон хууль, тогтоомжид заасан эрх үүргийг хэрэгжүүлэхдээ зөрчил гаргасан тохиолдолд хуулийн этгээдийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах саналыг Мэргэжлийн зөвлөлд тавьж, шийдвэрлүүлнэ.

5.11. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн талаарх мэдээллийг мэдээллийн санд байрлуулна.

Зургаа. Бусад

6.1. Энэ журмыг болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн, ёс зүйн зөрчил гаргасан, үнэлгээний ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн, шаардлага хангаагүй тайлан, дүгнэлт, хүлээн авсан нь тогтоогдвол холбогдох албан тушаалтан, этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны
... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Онцгой байдлын ерөнхий газрын дарга
- Орлогч дарга: Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан дэд дарга
- Гишүүд: Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга;
Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга;
Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга;
Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын дарга;
Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын Хуулийн тасгийн дарга;
Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн захирал;
- Зөвшилцсөнөөр: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргаа удирдлагын газрын орон нутаг, иргэний нийгэм, гамшиг, дайчилгаа хариуцсан мэргэжилтэн;
Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
Соёлын яамны Соёлын өвийн газрын дарга;
Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн, гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан;
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Санхүүгийн хэлтсийн дарга, гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан;

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны
Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын шинжээч;

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн
бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын
Лавлагаа шатлалын тусламжийн хэлтсийн
гамшгийн үеийн бэлэн байдал, яаралтай
тусламж хариуцсан мэргэжилтэн;

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Дэд
бүтцийн хяналтын газрын дарга;

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын
сургуулийн захирал;

Иргэний нийгмийн төлөөлөл.

Нарийн бичгийн дарга:

Онцгой байдлын ерөнхий газрын Гал
түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын
хяналтын хэлтсийн дарга;

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн
эрсдэлийн удирдлагын газрын Гамшгийн
эрсдэлийн үнэлгээний хэлтсийн дарга.

--o0o--